



ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 01 сарын 08 өдөр

Дугаар А/09

Улаанбаатар хот

2018 онд бараа, ажил, үйлчилгээ
худалдан авах ерөнхий төлөвлөгөө
батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.4 дэх заалт, Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын 2018 онд бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
2. Худалдан авах ажиллагааг батлагдсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулахыг холбогдох нэгжүүдэд, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлага, хамтын ажиллагааны газар /Р.Ганхуяг/, Санхүү, эдийн засгийн хэлтэс /Л.Лувсан/-т тус тус даалгасугай.

ДАРГА



Ц.ГАНХҮҮ

08 180034

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн
газрын даргын 2018 оны 01 сарын 08-ны
өдрийн 109 дугаар тушаалын хавсралт





2018 ОНД БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ
ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Санхүүжилтийн эх үүсвэр: Урсгал төсөв

№	Тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ, хүчин чадал	Төсөвт өртөг /сая.төг/	Худалдан авах ажиллагаанд мөрдөх журам	Худалдан авах ажиллагаанд мөрдөх хугацаа				Тайлбар, тодруулга
				Үнэлгээний хороо байгуулах огноо	Тендер зарлах огноо	Гэрээ байгуулах, эрх олгох огноо	Гэрээ дуусгавар болгох, дүгнэх огноо	
1	Тариалан болон атаршсан газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажил /17 аймаг, нийслэл/	171.2	НТШ	I/25	II/1	III/30	XI/1	ИХМХ
2	Хот суурин газрын хянан баталгааны ажил /Архангай, Баянхонгор, Сүхбаатар, Хэнтий аймаг/	102.0	НТШ	I/25	II/1	III/30	XI/1	ИХМХ
3	2015 онд суулгасан Улсын геодезийн эхлэл цэгийн төвтэй нивелирдлэгийн 1 дүгээр ангийн сүлжээг 2 шугамаар холбон геометрийн нивелирдлэгийг өндрийн I ангийн нарийвчлалаар хийх	260.0	НТШ	I/25	II/5	IV/16	XI/20	ГЗЗХ
4	Газар эзэмших, ашиглах гэрчилгээг үргэлжлүүлэн хэвлүүлэх	60.0	-	-	-	-	-	КХ
5	Нэгж талбарын хувийн хэргийн болон архивын хавтас үргэлжлүүлэн хэвлүүлэх	50.0	-	-	-	-	-	КХ
6	Кадастрын нууцлал бүхий цаас үргэлжлүүлэн хэвлүүлэх	60.0	-	-	-	-	-	КХ
7	Хорт код эсэргүүцэгч програмын гэрээ үргэлжлүүлэн сунгах	16.0	-	-	-	-	-	ОЗМТХ
Нийт		719.2						

Хянасан: СЭЗХ-ийн дарга

Боловсруулсан: ЗУХАГ-ын а/м

 Л.Лувсан
 О.Дөлгөөнтуул